



## ОРЧНЫ БОХИРДЛЫГ БУУРУУЛАХ ҮНДЭСНИЙ ХОРООНЫ ТОГТООЛ

2019 оны 9 сарын 19 өдөр

Дугаар 19/15

Улаанбаатар хот

Нам даралтын халаалтын зууханд  
сайжруулсан түлш хэрэглэх тухай

“Агаарын бохирдлыг бууруулахтай холбогдуулан авах арга хэмжээний тухай” УИХ-ын 2018 оны 02 дугаар тогтоолын 4 дэх заалт, “Агаар, орчны бохирдлыг бууруулах үндэсний хөтөлбөр батлах тухай”, Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 98 дугаар тогтоолын 2.2.2 дэх хэсэг, “Агаарын бохирдлыг бууруулах талаар авах зарим арга хэмжээний тухай” Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 43 дугаар тогтоолын 1.1 дэх хэсэг, Монгол Улсын Ерөнхий сайдын 2017 оны 51 дүгээр захирамжийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсэг, Орчны бохирдлыг бууруулах Үндэсний хорооны 2019 оны 19/04 дүгээр тогтоолын 3 дугаар зүйлд тус тус заасныг үндэслэн Орчны бохирдлыг бууруулах Үндэсний хорооноос ТОГТООХ нь:

1. Агаарын чанарыг сайжруулах бүсэд үйл ажиллагаа явуулж байгаа бага чадлын 16-100 квт хүчин чадалтай 1740 ширхэг халаалтын зуухыг сайжруулсан түлшээр хангах, нөөц бүрдүүлэх ажлыг зохион байгуулахыг Улаанбаатар хотын Ерөнхий менежер бөгөөд Захирагчийн ажлын алба /Т.Гантөмөр/-д, Таван толгой түлш ХХК-н гүйцэтгэх захирал /М.Ганбаатар /-д тус тус даалгасугай.

2. Нийслэлийн Агаарын чанарын бүсэд байгаа 290 халаалтын зууханд утаа шүүгч шүүлтүүр суурилуулах ажлыг 2019 оны 10 дугаар сарын 01-ны өдрийн дотор хийж гүйцэтгэхийг Орчны бохирдлыг бууруулах Үндэсний хорооны Ажлын алба /Г.Гантулга/-д даалгасугай.

3. Уг тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Орчны бохирдлыг бууруулах Үндэсний хорооны Нарийн бичгийн дарга бөгөөд Ажлын албаны дарга /Ч.Гантулга/-д үүрэг болгосугай.

БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН  
САЙД, ОРЧНЫ БОХИРДЛЫГ БУУРУУЛАХ  
ҮНДЭСНИЙ ХОРООНЫ ДАРГА

Н.ЦЭРЭНБАТ

